



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 2 сарын 5 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

III ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын III хурал 2020 оны 2 дугаар сарын 5-ны өдрийн 12.00 цагт Төрийн ордон дахь Шадар сайдын ажлын өрөөнд 75 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Улсын онцгой комиссын орлогч дарга, Батлан хамгаалахын сайд Н.Энхболд даргалж, холбогдох үүрэг, даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

- Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, цаашид шийдвэрлүүлэх асуудлын талаар Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Д.Сарангэрэл;
- “Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө”-г хэлэлцэж батлах асуудлаар Онцгой байдлын ерөнхий газрын Гамшгийн шуурхай удирдлагын газрын дарга, хурандаа Б.Мандахгэрэл нарын мэдээллийг сонсов.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн сайд Д.Сарангэрэлд:

- 1.1. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд холбогдох мэргэжлийн байгууллагуудтай хамтран, нөөц бололцоогоо дайчлан гоц халдварт өвчний үед өвчтөнг тусгаарлан хэвтүүлж, эмчлэх эмнэлгийн барилга, байгууламжийн асуудлыг шуурхай шийдвэрлүүлэхийг;
- 1.2. Гамшгийн үед ажиллах эмч, ажилтнуудыг томилгоожуулж, эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлж, техник тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангуулах;

1.3. Томуу, томуу төст өвчний дэгдэлт их байгаатай холбогдуулан олон нийтэх хандсан зөвлөгөө, сэргэмжлүүлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилан зохис байгуулахыг;

Хоёр. Зам, тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Энх-Амгаланд:

2.1. Монгол Улсын хилээр нүүрс, газрын тос, ачаа бараа, бүтээгдэхүү тээвэрлэж байгаа тээврийн компаниудад жолооч нарыг амны хаалт, бээлий, га халдвартгүйтгэлийн бодисоор хангаж, халдварт хамгааллын холбогдох дүрэм, журмын мөрдөж ажиллуулахыг;

Гурав. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Ч.Улаан,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Н.Цагаанхүү нарт:

3.1. БНХАУ-ын Хунань мужид шувууны томуугийн (H5N1) вирусийн халдвартын дэгдэлт бүртгэгдсэнтэй холбоотойгоор 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн хүртэл Монгол Улсын хилээр шувууны мах, өндөг, тэжээл оруулахыг түр хориглох шийдвэр гаргаж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг;

3.2. БНХАУ-аас импортолж буй бараа, бүтээгдэхүүн ариутгал, халдвартгүйтгэл хийх ажлыг зохион байгуулж, хүнсний зах, худалдааны төвүүдэд худалдаалагдаж байгаа бараа, бүтээгдэхүүний чанар, эрүүл ахуй, аюулгүй байдалд тавих хяналт, шалгалтыг сайжруулж, үүрэг чиглэл өгч ажиллахыг;

Дөрөв. Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн С.Наранцогт,

Төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүлэн захирагч нарт:

4.1. Коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах, бэлтгэл, бэлэн байдлыг хангах ажлын хүрээнд тухайн салбарт нэн шаардлагатай байгаа хөрөнгийн асуудлыг 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн дотор салбар бүрээр нэгтгэн Сангийн яаманд хүргүүлж, Төсвийн тухай

хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу 2020 онд батлагдсан төсөвтөө зохицуулалт хийх замаар шийдвэрлүүлж, Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг;

Тав. Гадаад харилцааны яамны

Төрийн нарийн бичгийн дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Д.Даваасурэн,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга,

бригадын генерал Ж.Бямбасурэн нарт:

5.1. Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 39 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсгийн **Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийн агаарын зам, төмөр зам, авто замын бүх боомтоор Бүгд Найрамдах Хятад Ард Улсын иргэд гэдэгт БНХАУ-ын засаг захиргааны онцгой бүс Хонгконг, Макао, Тайванийн нутаг дэвсгэрт өвчин бүртгэгдсэн гэдэг агуулгаар нь хамааруулж, зохих арга хэмжээ авч ажиллахыг;**

5.2. БНХАУ-д гарсан шинэ коронавирусийн халдвартын улмаас Засгийн газрын 2020 оны 39 дүгээр тогтоолын 1.2-т 2 дугаар сарын 6-ны өдрөөс 3 дугаар сарын 2-ны өдрийг хүртэлх хугацаанд БНХАУ-аас ирэх Монгол Улсын иргэдийг агаарын замын Буйант-Ухаа боомт, төмөр замын Замын-Үүд боомтоор улсын хилээр нэвтрүүлэх шийдвэр гаргасан.

Гэвч БНХАУ дотооддоо хөл хорио тогтоосны улмаас Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянхшуу, Булган, Бичигт боомтын эсрэг талд байгаа монгол иргэд Эрээн хотод очих боломжгүй болсон тул Хятадын талтай Хилийн төлөөлөгчийн шугамаар хамтран ажиллаж, авто замын хилийн боомтуудаар монгол иргэдийг тухай бүр улсын хилээр нэвтрүүлэхийг;

Зүргаа Улсын онцгой комиссын орлогч дарга,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга,

хошууч генерал Т.Бадралд:

6.1. БНХАУ-тай хиллэдэг хилийн боомтуудын үйл ажиллагаатай газар дээр нь танилцах, цагийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгөх, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх үүрэг бүхий "Шуурхай бүлэг томилох тухай" Улсын онцгой комиссын даргын тушаал, удирдамжийг 2020 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн дотор батлуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг;


Долоо. Засгийн газрын Хэвлэл мэдээлэл,
олон нийттэй харилцах хэлтсийн дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Ц.Ганзоригт:

7.1. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний талаарх үнэн бодит мэдээллийг насны ангилалд тохируулан иргэдэд шуурхай, хүртээмжтэй хүргэхийг тус тус үүрэг болгов.

Тайлбар: "Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээний салбар дундын төлөвлөгөө"-г Улсын онцгой комиссын гишүүдийн 100 хувийн саналаар дэмжиж батлав.

ОРЛОГЧ ДАРГА,

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД



НЭНХБОЛД